



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 22

Мөрөн сум

Г Орон нутгийн өмчit компаниудын
төлөөлөn удирдах зөвлөлийн
зарим гишүүдийг томилох эрх олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт, орон нутгийн өмчit компаниудын дүрэм, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдааны 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн орон нутгийн өмчit зарим компаниудын Төлөөлөn удирдах зөвлөлийн гишүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдаанд танилцуулсан нэрсээр Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулан томилох эрхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхүяг)-д олгосугай.

2. Төлөөлөn удирдах зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинзорогдог), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга (Р.Машбат) нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.МӨНГӨНХҮЯГ

